



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 95

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.14 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-ийг мэдээллээр хангах байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-ийн мэдээллээр хангах журамд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга/Д.Батлут/-д үүрэг болгосугай.

3. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-д хүргүүлэх мэдээллийг тогтоосон хугацаанд ажлын хэсэгт ирүүлэхийг салбар хариуцсан төрийн байгууллагуудад даалгасугай.

ДАРГА  ПЛҮРЭВЛХАГВА



0010300